



НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Ажлын цагийн хуваарьт
зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18, 16.5.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/217 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн хөгжил, боловсрол, эрүүл мэндийн асуудал хариуцсан орлогчийн 2022 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 02-03/952 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн авто замын ачааллыг бууруулах зорилтын хүрээнд хүүхэд нь ерөнхий боловсролын сургуульд суралцдаг албан хаагчдын санал, хүсэлтийг үндэслэн байгууллагын ажлын цагийн хуваарьт дараах зохицуулалтыг 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс 2021-2022 оны хичээлийн жил дуустал хугацаанд ажил эхлэх цагийг 08:00, үдийн цайны завсарлагыг 12:00-12:30, тарах цагийг 16:30 цаг байхаар тогтоосугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Ж.Балжинням), Хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Орхонбайгаль)-т үүрэг болгосугай.

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ГАНБОЛД

1150500037